

VIII Богд Жавзандамба хутагт монголын улс төрийн хошуучлагч болох нь

Аюушийн Хишигдаваа, докторант
Шинжлэх Ухааны Академийн Философийн Хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс,
khishigdavaaa@mas.ac.mn; <https://orcid.org/0009-0002-5550-4284>

Article history

Received : 2024-08-31
Accepted : 2024-09-18
Published : 2024-12-20

Түлхүүр үгс

улс төр,
улс төрийн
хошуучлал, түүх,
улс төрийн бодлого,
эрх чөлөө,
тусгаар тогтнол

Хураангуй: VIII Богд Жавзандамба хутагт бол Монгол Улсаа эрх чөлөөтэй, тусгаар улс болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн төрийн зүтгэлтэн юм. Тэрээр 1900-аад оноос эхлэн үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо баталгаажуулах гадаад, дотоод бодлогыг тууштай явуулж, үр дүнд хүрч, амжилт олсон билээ. Жавзандамба хутагт шашны зүтгэлтэн төдийгүй улс төрийн хошуучлагч, нийгмийн оюун санааны удирдагч байв. Бид энэхүү өгүүлэлдээ түүнийг “*улс төрийн хошуучлагч*” талаас нь тодотгон гаргахыг зорьсон болно. XX зууны эхэн гэхэд Ар Монгол төдийгүй монгол туургатанд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд, нөлөө бүхий шашин, улс төр, нийгмийн зүтгэлтэн бол Жавзандамба хутагт байв. Түүнд нийгмийн оюун санааг удирдан чиглүүлэх хүч нөөцөөс гадна захирах хамжлага, шавь нар, дэмжигч сүсэгтэн, ард иргэдийн тойрон хүрээлэл байжээ. Мөн Манж Чин гүрний төрд зүтгэж байсан хэдий боловч тусгаар тогтнолоо сэргээн мандуулах зорилго бүхий монгол ноёд, төр, цэрэг, шашны зүтгэлтнүүдийн дэмжлэг юм. Тэдний үзэл бодол, зорилгыг нэгэн зүгт хандуулж, нэгтгэн зангидаж чадсанд 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын ололт, амжилт, үнэ цэн оршиж байгаа ажээ. Жавзандамба хутагтын улс төрийн бодлого нь Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, Сайн ноён хан Намнансүрэн, Түшээ гүн Чагдаржав, Хайсан гүн зэрэг хамтран зүтгэгч сайд нарын гадаад, дотоодод явуулсан улс төр, эдийн засаг, цэрэг дайны үйл ажиллагаагаар тодрон илэрч байна. Түүхэн үйл явдлуудаас үзэхэд зөвхөн Ар Монголоор хязгаарлаад зогсохгүй, Өвөр Монгол, Буриад, Тагна урианхайг нэгтгэсэн “Монгол туургатан”-ны улс байгуулахыг зорьж байжээ. Энэхүү зорилго нь бүрэн дүүрэн хэрэгжиж чадаагүй ч 200 гаруй жил болсон Манж чин гүрний эрхшээлээс Монгол Улсаа гаргаж, тусгаар тогтнолоо зарлан тунхагласан нь түүний үлэмж гавьяа юм. Жавзандамба хутагт 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагч төдийгүй, 1921 оны ардын хувьсгалын үйл хэрэгт ч чухал нөлөө, түлхэц өгсөн улс төрийн хошуучлагч ажээ.

Keywords

politics,
political leadership,
history,
political policy, freedom,
independence

© The Author(s), 2024



VIII Bogd Javzandamba became Mongolia's political leader

Khishigdavaa Ayush (Ph.D candidate student)

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia, khishigdavaaaa@mas.ac.mn; <https://orcid.org/0009-0002-5550-4284>

Abstract: VIII Bogd Javzandamba was an important politician who made Mongolia a free and independent country. Since the 1900s, the State has pursued foreign and domestic policies aimed at ensuring national freedom and independence, and has achieved results and success. Bogd Javzandamba is not only a religious figure, but also a political and social leader. This document focuses on the views of “political leaders”. In the early 20th century, Bogd Javzandamba was recognized as a prominent religious, political and social figure not only in Mongolia, but also in Mongolia. He not only led the spirit of society, but he had a circle of rulers, followers, faithful supporters, and citizens. Manchu also worked for the Qing Government, but sought independence by securing support from Mongolia's Prince, Government officials, and military and religious figures. The success, success and value of the 1911 National Liberation Revolution were based on their ability to unite their views and objectives. The political policy of Bogd Javzandamba is evident in the political, economic and military activities of colleagues such as Chin van Khanddorj, Da Lama Tserenchimed, Sain noyon Khan Namnansuren, Tushee Chagdarjav and Chaisan Gun. According to historical facts, the aim was to establish the “Mongolian Tuurgatan” state, which included not only the interior of Mongolia, but also the interior of Mongolia, Buriad and Tagna Uriankhai. Although this goal has not yet been fully achieved, it is a great achievement that he removed Mongolia from the Qing Dynasty of Manchu in over 200 years and declared its independence. Bogd Javzandamba was not only the leader of the 1911 National Liberation Revolution, but also a political leader who had a significant influence and dynamism in the 1921 People's Revolution.

I. Оршил

XIX зууны сүүл үеэс Монгол орныг эрхшээж байсан Манж чин гүрэн сулран доройтож эхлэв. Энэхүү доройтлоо намжааж гэтлэн давахын тулд “Шинэ засгийн бодлого” гаргаж хэрэгжүүлсэн боловч төдийлөн амжилт олоогүй юм. Чин улсын хэмжээгээр явагдсан эл бодлогод Монгол орон өртөв. Монголд хамгийн түрүүнд хэрэгжүүлсэн арга хэмжээ бол хятад тариачдыг Өвөр Монголын нутагт ирж суурьшуулахаар шийдвэрлэж, хятад засаг захиргааны байгууллагыг байгуулж, Ар, Өвөр Монголыг муж

болгон өөрчлөх гэсэн оролдлогоор эхэлсэн юм. Энэ бодлогыг эсэргүүцсэн тэмцэл, хөдөлгөөн Ар, Өвөр Монголд тасралтгүй өрнөх болсон нь монгол угсаатан үндэсний тусгаар тогтнолоо сэргээх, эвлэлдэн нэгдэх үйлсэд чухал түлхэц болсон юм.

Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэлд Ар Монголын шашны тэргүүн, VIII Богд Жавзандамба хутагтын гүйцэтгэсэн түүхэн үүрэг томоохон байр суурийг эзэлдэг. Чин гүрний “Шинэ засгийн бодлого”-ыг Монголд хэрэгжүүлж эхэлсэн үеэс

түүнийг эсэргүүцэн, хэрэв энэ арга хэмжээ хэрэгжвэл “Монголчуудын язгуурын ёс” алдагдахад хүрнэ хэмээн үзэж байв. Эл “язгуурын ёс” гэдэг нь *«Монголын аж ахуй, хэл соёл, хэв заншил, үндэсний өвөрмөц онцлог, шашин шүтлэгийг алдагдуулахад хүргэхгүй байх, улмаар Монголын газар шороог бусдад алдахгүй байх, эцэст нь монголын тусгаар тогтнолыг сэргээх саналыг агуулж»* (ШУА, Түүхийн хүрээлэн 1995, 8) байсан учир нийт монголчуудын дэмжлэгийг хүлээж чадсан байна. Монголын Үндэсний эрх чөлөөний хувьсгалын бусад удирдагчид ч Богд Жавзандамбын асар их нэр нөлөөг ашиглан бүх Монголчуудыг бурхны шашны тугийн дор нэгтгэх аргыг хэрэглэх нь амжилт олох чухал үндэс гэдгийг сайтар ойлгож байжээ. Монголд бурхны шашин дэлгэрсэний үр дүн энэ үед гарсан бөгөөд тархай бутархай Монголчууд нэгэн шүтлэгтэн болсноор оюун санааны барилдлагаар холбогдож тэднийг улс төрийн талаар эвлэлдэн нэгдэх хүчин зүйл болж байв.

Төрт ёсны үндэс, бүтээгч нь үндэстэн мөн. Үндэстний аж төрөх ухаан, ёс заншил, шашин суртал, сэтгэлзүйн болон үнэлэмжийн онцлог, төрөө барих, засах арга ухаанаас салангид зүйл огтхон ч биш юм. Харин ч түүний мөн чанарыг тодорхойлдог гол хүчин зүйл мөн. “Үндэстэн” гэсэн ойлголт судлаач, сэтгэгчдийн судалгааны эргэлтэд эртнээс орж, цагийн аясад өөрчлөгдөн хөгжиж ирсэн байна (Лүндэндорж Н. 2002, 10). Үндэстэн гэдэг бол хэл, газар нутаг, эдийн засаг, соёлын нийтлэг байдалтай [ардтүмэн](#) юм. Үндэстэнд тухайн нутагт

амьдарч буй үндэстний төлөөлөгчдөөс гадна өөр үндэстэн ястны нутагт амьдарч байгаа төлөөлөгчид нь ч бас багтана. Үндэстэн бүр бие даан хөгжих хандлагатай байдаг. Эдийн засаг, амьжиргааны үр ашгийн тулд үндэстэн ойртох хандлага бий болдог байна. Энэхүү ойртон нягтрах үйл явц дунд төрт ёсны тулгуур үзэл санаа үндэсний үзэл боловсорч байдаг. Дээрх үзэл хандлагын дагуу 200 гаруй жил Манж чин улсын эрхшээлд байсан монгол үндэстэн нэгдэн нягтрах үйл явц өрнөсөн юм. Уг үйл явц Ар, Өвөрмонголын нутаг дэвсгэрт хүчтэй явагдаж, улс төр, нийгмийн оюун санаа, шашин соёлын нэгдмэл үзэлд тулгуурлаж байв. Ар, Өвөр Монголын олон хошуудад Манжийн төрийг эсэргүүцэж, үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээх давалгаа хүчирхэгжсэн юм. 1368 оноос Монголын Их Юан гүрэн аажмаар сулран доройтож, 1636 онд Өвөр Монгол, 1691 онд Ар Монгол, 1755 онд Ойрад Монгол Манж Чин улсын эрхшээлд орсон билээ. Гэсэн хэдий ч монгол үндэстэнд өөрийн төр улсаа сэргээн байгуулах чин эрмэлзлэл тэдний оюун санаа, үзэл бодолд оршсоор байв. Алтан ургийн тайж, ноёд өвөр зуураа хэлэлцэн тохиролцож, хувьсгалын тохироо бүрэлдэх мөчийг хүлээж суусан ажгуу. Ингэхдээ Чингис хааны баримталж байсан төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх суурь зарчмыг сайтар уламжлан авч, хойч үедээ дамжуулан үлдээж байв. Тэдний ихэнх нь Манжийн төрд хүчин зүтгэж байсан хэдий ч уг чанартаа Монгол Улсаа шинээр сэргээн мандуулах чин хүсэл

зорилготой байсан нь илэрхий байдаг. Түүхэн үйл явдлын өрнөл ч үүнийг гэрчилдэг. Нүүдэлчин монголчуудын оюун санааны салгаж болшгүй мөн чанар бол эрх чөлөөг эрмэлзэх, амар амгалан аж төрлийг дээдлэх, хэрэгцээ гарвал түүнийхээ төлөө амьдралаа зориулах эр зориг юм (Дулам С. 2015, 232). Үндэсний эрх чөлөөний удирдагчид үзэл бодол, үйл хэргээсээ огтхон ч няцалгүйгээр Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө чин шударгаар зүтгэснийг түүхэн үйл явдал, баримтууд илтгэн харуулдаг. Манж чин улсын сүр хүч сулран доройтсон цаг үеийг соргоогоор мэдэрч, Хаант Орос улсаас зохих тусламж дэмжлэг хүсэж, тусгаар тогтнолоо зарлан тунхаглаж чадсан нь чухал амжилт болсон юм.

II. Үндсэн хэлэлцүүлэг

Бид энэ удаа VIII богд Жавзандамба хутагтын үндэсний эрх чөлөө, Монгол Улсын тусгаар тогтнолыг сэргээн мандуулахад оруулсан хувь нэмрийг улс төрийн хошуучлагчийн талаас нь үнэлэн цэгнэхийг зорьсон болно. Ингэхдээ түүний улс төрийн бодлого, үйл ажиллагааны бодит түүхэн баримтуудад тулгуурлаж авч үзэх нь чухал хэмээв.

VIII богд Жавзандамба хутагт бол Монгол Улсын үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолыг сэргээн мандуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан улс төрийн хошуучлагч юм. Тэрээр 1869 онд Төвдийн Лхас хотын ойролцоо Гончигцэрэн, Ойдүвдулам нарын гэрт төржээ. Таван настайдаа Жавзандамба хутагтын хойд дүрээр тодорч Их хүрээнд иржээ. Чингис хааны угсаа, Халхын Түшээт хаан Гомбодоржийн

хөвүүн анхдугаар богд Жавзандамбын хойд дүр тул Монгол төрийн үйл хэрэг, хувь заяа өөрт нь хамаатай гэж үздэг байв. Түүнийг багаас нь эхлэн ар халхын эрдэм мэдлэг бүхий багш нар “Монгол хүн” болгон төлөвшүүлж чадсан ажээ. Номын төдийгүй, төрийг засах эрдмийг тусгайлан зааж сургасан байна. Монголчуудын төр засах, төрийн хэргийг гүйцэтгэх уламжлалт ухааныг үзэл санаандаа суулгасан юм. Хэдийгээр төвд гарал угсаатай хүн байсан ч гэсэн хэл соёл, зан заншил, өсөж хүмүүжсэн орчноо дагаад монгол сэтгэлгээтэй, шашин төрийн зүтгэлтэн болжээ.

Монголын түүхч Л.Дэндэв бичихдээ «...Манж-Хятадын эзэрхэг харгисын хэтэрхий дарлалуудыг олон онд эдэлж, зовлон гашуун нь өрнөж дасашгүй болсон учир...тэрхүү зовлон зүдгүүрээс хэрхэн ангижрах арга замыг эрэлхийлж, Ар, Өврийн олон монголчууд бичиг мэдээгээр харилцан нэвтрэлцэж ахуй цаг, Богд Жавзандамба хутагтаас 1900 онд да лам Бадамдорж, зайсан Цэрэн-Очир нарыг их Орос улсын засгийн газраа тусгай захидал бэлэг авахуулан одуулж тусламж хамгааллыг гуйсныг Орос улсаас тэр даруйд хэрэг болгож үзсэнгүй хойшлуулсан зүйл буй...» (Дэндэв Л. 1934, 1) гэсэн байдаг. Тэгэхээр үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээсэн 1911 оны үйл явдлаас даруй 10-аад жилийн өмнөөс эхлэн Орос улсаас тусламж хүсэж, элч илгээж, холбоо тогтоож, тэднийг түшиглэн тусгаар тогтнолоо сэргээхийг эрмэлзэж байв.

Улс төрийн хошуучлагч нь тусгаар тогтнолын үзэл санааг өөртөө

хийгээд ард иргэдийн ухамсарт гүн бат шингээсэн байдаг. Богд Жавзандамба хутагт ч үүнийг машид эрхэмлэж байсан нь маргаангүй юм. Францын сэтгэгч Жан Бодин анх XII зууны дунд үед тусгаар тогтнолын үзлийг шинжлэх ухааны онолын үүднээс цэгцтэй боловсруулан улс төрийн онолын бие даасан баримтлал болгон олон түмэнд түгээсэн байдаг. Тусгаар тогтнолын үзэл санаа нь үндэсний ардчилсан үзэл санааны дотоод мөн чанарын илэрхийлэл юм. Тусгаар тогтнол нь ямар нэг харийн улс орны эрхшээл, шахалтанд орохгүйгээр зөвхөн үндэсний эрх ашиг, ард түмнийхээ хүсэл зорилгод нийцүүлэн, төрийн гадаад дотоод бодлогыг боловсруулах хэрэгжүүлэх боломж, энэ тухай улс төр, эрх зүйн үндэсний болон олон улсын шинжтэй баталгааг нөхцөл бүрэлдсэн байхыг хэлнэ (МУИС. 1999, 151-152). Богд Жавзандамба хутагтын 1900-аад оны үеэс эхлэн санаачилсан улс төрийн үйл ажиллагаанд Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, Түшээ гүн Чагдаржав, Хайсан гүн нарын үзэл бодол ихээхэн түлхэц өгсөн юм.

Тэд 1911 оны 6 дугаар сарын 21-нд Богд Жавзандамбад “Бат оршил” өргөх ёслолын үеэр Их Хүрээнд нууц зөвөлгөөн хийжээ. Энэхүү зөвөлгөөнөөр Манж Чин улсын “Шинэ засгийн бодлого”-ыг монголын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, монгол үндэстэн, угсаатанд ноцтой аюул учруулж байна хэмээн үзсэн. Манж Чин улсын дотоод зөрчил хийгээд сулран доройтож байгаа байдлыг ашиглан үндэсний тусгаар тогтнолоо сэргээх нь чухал хэмээн тогтов. Чин ван

Ханддорж, да лам Цэрэнчимэд, түшээ гүн Чагдаржав нар Богд уулын аманд нууцаар хуралдаж, Хаант Орос улсаас тусламж хүсэх нь тусгаар тогтнолоо сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн шийдвэрлэжээ. Үүнийг Богд Жавзандамба хутагт хүлээн авч, дэмжин шийдвэрлэж, хаант Орос улсад элч илгээсэн юм. Төлөөлөгчдийн тэргүүнээр Чин ван Ханддорж, гишүүнээр да лам Цэрэнчимэд, Өвөрмонголын Зостын чуулганы Харчин баруун гарын хошууны түшмэл Хайсан нарыг томилсон аж. Тэд Богд Жавзандамба болон Түшээт хан Дашням, Сэцэн хан Навааннэрэн, Засагт хан Содномравдан, Сайн ноён хан Намнансүрэн нарын үйлдсэн бичгийг авч, Хаант Орос улсыг зорьсон байна. Оросын эзэн хаанд бичсэн албан бичигт хэд хэдэн тодорхой санал дэвшүүлжээ. Тухайлбал, Монголд явуулж буй Манж чин гүрний бодлогыг буруушааж, Хаант Орос улстай харилцаагаа зузаатгаж, тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэхийг чухалчилсан байна. Ингэхдээ харилцан ашигтай байх саналыг тавьж, худалдаа хийх, төмөр зам тавих, алт мөнгөний уурхай байгуулах, шуудан харилцааг өргөтгөх, цэргийн сургууль байгуулахыг тусгайлан хэлэлцэж болохыг онцолжээ. Мөн Богд Жавзандамбыг Монголын хаан ширээнд залж, тусгаар улс болохыг нийт монголчуудын дийлэнх нь дэмжиж буйг давхар илтгэжээ. Төлөөлөгчдийн тавьсан эдгээр саналыг Хаант Оросын эрх баригчид хүлээн авч, 1911 оны YIII сарын 17-нд хаант Орос улсын сайд нарын зөвлөлийн даргаар удирдуулсан, холбогдох

яамдын сайд нар болон бусад албан тушаалтнууд оролцсон Монголын талаарх зөвөлгөөн зохион байгуулжээ. Уг зөвөлгөөнөөс Монгол болон Манж чин улстай харилцах харилцааны талаар баримтлах бодлого, чиглэлийг гаргасан байна.

Манж чин улсын Монголд явуулж байгаа бодлого, үйл ажиллагаа Хаант Орос улсын ашиг сонирхлыг хөндөж байсан учраас анхаарал хандуулах шаардлага зүй ёсоор гарч ирэв. Энэ нь Орос улс баруун талдаа Герман улстай хийх дайнд бэлтгэж байсан тул дорно зүгт найдвартай ар тал чухал байв. Иймээстөлөөлөгчдийнтавьсансаналыг хэлэлцээд, Монголын асуудал ихээхэн ач холбогдолтой болохыг тэмдэглээд, «...Монголоос Чин улстай тогтоосон сюзерений холбоог таслалгүйгээр үндэсний байдлаа хамгаалах гэсэн монголчуудын эрмэлзлийг дипломат замаар дэмжих» (Международные отношения в эпоху империализма: (1870-1910) 1938-1939, 341) хэрэгтэй хэмээн үзжээ. Тэд «Монгол одоохондоо Чин улсаас тусгаарлах боломжгүй, харин монголд явуулж байгаа үйл ажиллагаанаас татгалзах талаар Бээжинд мэдэгдэл өгье. Хятадаас монголчуудын эсрэг хийж болзошгүй аллага хядлагаас сэргийлж, Их хүрээн дэх Консулын газрыг хамгаалах хүчийг нэмэгдүүлэхээр амалсан» ажээ. Тун удалгүй Монголын төлөөлөгчдийг Орос улс руу нууцаар явж, Чин улсаас салан тусгаарлах тусламж гуйсан нь мэдэгдэж, Чин улс даяар ихэд тархсан бөгөөд Хятадын зарим хэвлэлд энэ тухай бичиж байжээ.

Хүрээний сайд Сань До, Ар Халхад болж буй энэхүү үйл явдлыг

Чин улсын засгийн газарт уламжлахын зэрэгцээ, Богд Жавзандамба хутагтад «Оросын цэргийг Монголд ирүүлэхгүй байх, Ханддорж нарыг даруй Хүрээнд дуудан ирүүлэх цахилгаан утсыг явуул» хэмээн шахалт үзүүлсэн байна. Жавзандамба хутагт үүний хариуд, «... Хэрэв Монголд явуулах гэж буй шинэ засгийн бүх хэргийг хүчингүй болгож, Орос улсад явсан төлөөлөгчдөд ямар нэгэн ял зэмлэл хүлээлгэхгүй гэсэн баталгаа гаргавал, цахилгаан утас явуулж болно» гэж хариу мэдэгдсэн байна. Сань До 1911 оны ҮШ сарын дундуур энэ бүх байдлыг тодорхойлж Чин улсын эзэн хаанд айлтгасанд удалгүй ёсоор болгож, зарлиг буулгжээ (Түүхийн хүрээлэн. 1972, 49). Чин улсын захиргаа Бээжин дэх Орос улсын элчинд IX сарын эцсээр, дараа нь Петербург дэх түр хамаарагчаараа дамжуулан, Оросын ГЯЯ-нд мэдэгдэхдээ, «Монголд хийж байгаа цэрэг улс төрийн өөрчлөлтийг зогсоолоо» (Международные отношения в эпоху империализма: (1870-1910) 1938-1939, 20) хэмээсэн байна. 12 дугаар сарын 26-нд Чин улсын засгийн газраас ирүүлсэн цахилгаанд цэрэг бэлтгэх газрыг татан буулгахыг зөвшөөрч, Сань До-г Их Хүрээний сайдын тушаалд хэвээр байлгана гэж мэдэгдсэн ажээ. Орос улсад явсан төлөөлөгчид уван цуван буцаж ирсний дараа Их Хүрээнд Монголын тусгаар тогтнолыг тунхаглах бэлтгэл ажил шаргуу хийгдэж эхэлжээ. Энэхүү үйл явдал нь Богд Жавзандамба хутагтын гадаад улс төрийн үйл ажиллагаа үр дүнд хүрснийг илтгэж байгаа юм.

1911 оны 12 дугаар сарын 28-нд Монголын ноёд, дээд лам нар

Жавзандамба хутагтад айлтгахдаа «..Одоо өмнө газар их самуун дэгдэж олон шинэ төр байгуулан улс болон тогтож буй чимээ машид олон болсон ба Манжийн хаан аймагтны эрх мэдэл тун ч өчүүхэн болжээ. Иймд шавь нар бид бүхэн яахин хүмүүжвээс сайн болохыг тодорхойгоор айлдахыг хүснэ» гэжээ. Үүний хариуд Жавзандамба хутагт лүндэн буулгахдаа, «...Таны ийнхүү асуусан нь маш сайн. Ер нь аливаа юманд цаг хэмжээгүй нь огт үгүй. Манж, хятадын энэ байдал мөн цаг болсны тулд болой. Одоо монгол овогтон бүгдээр нийлж, өөртөө улс болон тогтнож, шашнаа мандуулан бусдын эрх мэдэлд дарлагдах зовлон зүдгүүрийг үзэхгүй болох цаг болсон. Гэвч бүгдээрээ нэгэн сэтгэл хамт хүчин гаргаж чармайн зүтгэхийг харгалзана. Бас лам би олон монгол шавь нараа цөмийг нэгэн адил авралдаа авсаар бөлгөө. Миний энэ үгийг улам улмаар лам надад мөргөхөөр ирдэг олон монгол шавь нарт нийтээр нэгэн адил сонсговол зохино» (МУТТА огноо байхгүй) гэжээ. Энэхүү лүндэн нь Монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эрхэм зорилго болсон бөгөөд Их Хүрээн дэх нөлөө бүхий ноёд, лам нар хэрхэн хэрэгжүүлэх тухай хуралдан хэлэлцээд, “Халхын Хүрээний Газрын Бүгд Хэргийг Түр Ерөнхийлөн Захиран Шийтгэх Газар”-ыг 1911 оны XI сарын 30-нд байгуулжээ. Энэ нь түр засгийн газрын шинжийг агуулсан ба тэргүүнээр, Түшээт хан аймгийн чуулганы дарга засаг, улсын түшээ гүн Чагдаржавыг тохоон томилж, бүрэлдэхүүнд нь чин ван Ханддорж, да лам Цэрэнчимэд нарын 7 хүн багтжээ. Энэ байгууллага

нь бүх Монгол даяар үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж байгааг ашиглан, юуны урьд Их Хүрээн дэх Манж Чин улсын захиргааг түлхэн унагаж, Монголын тусгаар тогтнол, төр улсыг сэргээх үйл ажиллагаанд бэлтгэх, түүнийг зохион байгуулах үүргийг хүлээж байв. Жавзандамба хутагтын лүндэнг Өвөр Монголын засаг ноёд, Барга, Алашаа, Хөх нуурын Монголчуудад яаралтай дамжуулахдаа, Жавзандамба хутагтыг Монгол улсын хаан ширээнд өргөмжлөх гэж байгааг хамтад нь мэдэгдэж, Халхын 4 аймгаас тус бүр нэг мянган цэрэг дайчлах тухай тушаал гаргажээ.

Монгол ноёд, лам нар Хүрээний сайд Сань До-д очиж, Богд Жибзундамба хутагтын зарлигаар ирлээ хэмээн «...монголчууд бүх газар орноо өөрсдөө хамгаалж, бүрэн эрхт Их Монгол улсыг байгуулж, Богд Жавзандамбыг хаан болгон өргөмжлөхөөр тогтсон» хэмээн мэдэгдээд, түүнийг харьяат албаны хүмүүсээ авч, өртөө улаа хэрэглэж, монгол нутгаас гарч явахыг шаардсан байна.

Сань До дагалдах манж, хятад түшмэдээ дагуулан Оросын консулын газар хоргодохоор явсны дараа, Халхын Хүрээний Газрын Бүгд Хэргийг Түр Ерөнхийлөн Захиран Шийтгэх Газраас Чин улсын сайдын яамыг өөрчилж, сэргэн мандах яамдын суурь болгохоор бэлтгэв. Дараа нь Хүрээн дэх бүх хятад цэргийн зэвсгийг хураан авч, улмаар Оросын консулын газар хоргодож буй Чин улсын сайд түшмэдийг 12 дугаар сарын 4-нд монгол түшмэд цэргүүдээр харгалзуулан, Хиагт хүртэл өртөөгөөр Монгол нутгаас явуулжээ.

Манжийн он тооллыг халж, монголын 12 жилийн цагтоог баримтлан “цагаагчин гахай жил” гэж нэрлэхээр шийдвэрлэж, мөрдүүлэх болсон нь Монголыг сэргээн мандуулах үйл хэргийн эхлэл байв. Халхын Хүрээний Газрын Бүгд Хэргийг Түр Ерөнхийлөн Захиран Шийтгэх Газар, Монгол улсаа сэргээн байгуулах бэлтгэлийг төв орон нутагт яаравчлан зохион байгуулав. Цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн есөн буюу 1911 оны 12 дугаар сарын 29-ний баасан гарагт Жавзандамба хутагтыг Монгол улсын хаан ширээнд өргөмжлөн залах ёслол Их Хүрээнд болж, “Олноо өргөгдсөн Монгол улс” байгуулсныг албан ёсоор зарлан тунхаглажээ. Хааны зарлигаар Монгол улсын засгийн газрыг 5 яамтайгаар байгуулж, Монголын тусгаар тогтнолын төлөө идэвхтэй хүчин зүтгэгчдийг төрийн удирдах том албан тушаалд томилж, зэрэг хэргэм шагнажээ. Үүнээс гадна ахмад настнуудад мөнгө, таяг зэргийг тус тус шагнаан хүртээж, хүнд хөнгөн ялтныг өршөөж, бүрнээ хэлтрүүлэн сулласан байна. Энэ зарлигаар Монголын тусгаар улс байгуулах үйлийг сэдэж, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг удирдан зохион байгуулсан Түшээт хан аймгийн жанжин, засаг, хошой чин ван Ханддоржийг Гадаад хэргийг эрхлэн шийтгэх яамны, Их Хүрээний да лам Цэрэнчимэдийг Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны, Түшээт хан аймгийн чуулган дарга, засаг, улсын түшээ гүн Чагдаржавыг Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яамны, Сэцэн хан аймгийн хамаарсан жанжин, засаг, бэйс Гомбосүрэнг Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны,

Түшээт хан аймгийн улсад туслагч гүн, засаг Намсрайг Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайдаар тус тус томилж, хаант төрдөө үнэнч зүтгэх тангараг өргүүлж, цол хэргэмээр шагнасан байна. Тулгар тогтсон Монгол Улсын засгийн газрын тэргүүний үүргийг чин зүтгэлт Цэрэнчимэд да лам, тэргүүн сайдтай Дотоод яам гүйцэтгэж, бусад яамдаа ахалж байхаар болов. Халхын 4 хан болон бусад ноёд, төр, цэргийн зүтгэлтнүүд Богд Жавзандамба хутагтыг улс төрийн хошуучлагч хэмээн хүлээн зөвшөөрч байсны тод илрэл юм. [Хятадад](#) нийлэхийг ятгаж байсан Хятадын ерөнхийлөгч [Юань Шикай](#) -н ятгалга, сүрдүүлгийг Богд хаан эс зөвшөөрч, бүх монголчуудыг нэгтгэж нэгдмэл Их Монгол Улсыг сэргээн мандуулахыг зорьж байв. Түүний засгийн газрын сайдууд төрийн тусгаар тогтнолоо хүчирхэг улсуудаар хүлээн зөвшөөрүүлэхийг оролдож байсан юм.

Олноо өргөгдсөн Монгол улс байгуулагдахад Чин ван Ханддоржийг Гадаад хэргийн яамны тэргүүн сайдын албанд томилжээ. Тэрээр Монгол улсын тусгаар тогтнолыг бусад улсаар хүлээн зөвшөөрүүлэх нь юу юунаас илүү чухал хэмээн үзэж, гадаад улс гүрнүүдтэй харилцаа тогтоох бодлогыг эрчимтэй явуулсан байна. Ханддоржийн тэргүүлсэн Гадаад явдлын яам, Монгол Улс тусгаар улс болсон тухай Хаант Орос улс, Франц, Их Британи, Герман, АНУ, Бельги, Япон, Дани, Нидерланд, Австри зэрэг улсад 1912 онд албан ёсоор мэдэгдээд “Гэрээ байгуулан худалдаа нэвтрүүлж, найрамдлыг зузаатгана уу?” хэмээн

тодорхой санал дэвшүүлсэн байна. Ханддорж нэн тэргүүнд хойд хөрш Орос улстай ойртон нөхөрлөхийг эрхэмлэх нь шинэ тусгаар Монгол улсын тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд ач холбогдолтой хэмээн үзэж байв.

Энэ зорилгын хүрээнд Монголын Засгийн газар Ханддоржоор толгойлуулсан бүрэн эрхт төлөөлөгчөө Орос улсад илгээхээр шийдвэрлэснээр 1912 оны өвлийн дунд сарын 14-нд төлөөлөгчид мордож, өвлийн адаг сарын шинийн 4-нд Санкт-Петербургт очсон байна. Богд хаант Монгол улсын Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчид эхлээд хаант Орос улсад Гадаад хэргийн сайд Сазанов, Ерөнхий сайд Коковцев, Худалдааны сайд Тимашев нарын албаны хүмүүстэй удаа дараалан уулзаж, хэрэг зоригоо танилцуулжээ. Өвлийн сүүл сарын 17-нд Оросын эзэн хаан II Николай тэднийг хүлээн авч уулзсан байна. Ханддорж нарын зорьсон хэргийн зарим нь бүтэж, Хаант Оросын Засгийн газар 2 сая рублийн зээллэг өгсөн ба зэр зэвсгийн тусламж дараа өгөхийг зөвшөөрчээ. Ханддоржийн Англи, Франц зэрэг орнуудад зорчих гэсэн санаархал Оросын явуулгаар тасалдав. Тэр ч байтугай Петербургт байгаа олон улсын элчин сайд нартай уулзуулахгүй байх талаар Оросын Гадаад хэргийн яам зохих арга хэмжээ авсан ажээ. Гэсэн хэдий ч энэ ажил хэргийн айлчлал хойд хөрш Хаант Орос улстай эдийн засгийн талаарх харилцаагаа цаашид өргөтгөхөд томоохон түлхэц үзүүлжээ.

Богд хаан зарлигаараа Да лам Цэрэнчимэдийг Дотоод яамны тэргүүн сайдаар томилж, Дотоод яамны сайд

нь бусад яамдаа ахалж байсан учраас Монгол Улсын Засгийн газрын анхны тэргүүн гэж үздэг. Тэрээр сэргээн байгуулагдсан Монгол Улсын төрийн дотоод хэргийг чандлан сахих, эрх зүй, ёс суртахууны хэм хэмжээг даган биелүүлэхийг чухалчилж, төрийн үйл хэргийг цалгардуулахгүй байхыг ихэд хичээж байв. Төрийн ёслол хүндэтгэлийг үйл ажиллагааг зохион байгуулж, дотоод, гадаадын хэрэгт хамааралтай бүхий л бичиг баримтыг хянан нягталж, боловсруулж, төрийн тамгыг шинээр хийлгэж, хошуу орон нутагтай харилцах, төрөл бүрийн гэрээ хэлэлцээр байгуулах чухал ажлуудыг хариуцан гүйцэтгэж байв. Монгол Улсын Засгийн газрын тэргүүний хувьд Цэрэнчимэд урьд нь мөрдөгдөж байсан Манжийн төрийн хууль, тогтоомж, журам зааврыг хүчингүй болгож, үндэсний онцлог, уламжлалаа хадгалсан шинэ журмыг боловсруулан мөрдүүлэх шаардлага тулгарч, тэр бүх ажлыг санаачлан боловсруулж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулсан аж.

Да лам Цэрэнчимэд эхэн үедээ Оросын талынханд нэлээд итгэж байсан ч цагийн аясаар тэдний цаад санаа бодлыг танин мэдэж, улс орныхоо эрх ашгийн үүднээс тэдэнтэй хатуухан байр сууринаас харилцах болжээ. Оросууд түүнд дургүйцэхийн зэрэгцээ болгоомжилж эхэлсэн байна. Монголын байгалийн баялгийг дураар ашиглах концессуудыг хураан авч, зохих татварыг төлөхийг шаардаж, гэрээ байгуулж, Монголд худалдаа хийж буй гадаадын иргэдийг татвар төлөхөөр болгожээ. Улс оронд худалдааны үйл ажиллагаа

явуулж байгаа гадныхан хийгээд дотоодынхныг зохих журмын дагуу чангатгаж эхэлсэн юм. Энэхүү үйл ажиллагаа нь улс орны эрх ашгийг хамгийн эхэнд тавьж, түүнд харш үйл ажиллагаа явуулж буй хэнтэй ч эвлэрэхгүй чигч шулуун хандаж чадсаныг илтгэнэ. Тэр нэр цэвэр, бусдын нөлөөнд автдаггүйгээрээ ХХ зууны Монголын түүхэнд хамгийн их тод дүгнэлтүүдийг гадныхнаас авсан байдаг юм. Гадна, дотныхоны Да лам Цэрэнчимэдийг өөртөө татах, ямар нэгэн хээл хахууль өгөх гэсэн оролдлого бүр бүтэлгүйтэж байв.

Түүхч, академич С.Чулуун «... Да лам улс төрийн хэргээс гадна Монгол туургатны хувь заяаны талаар ихэд анхаарч, Богд хаан болон монголчуудын хүсэж байсан Монгол үндэстнийг нэгтгэсэн тусгаар улс байгуулж, цагаан хэрмээр заагласан хуучин хилээр нь улсын хилийг сэргээх гэсэн бодлогыг тууштай баримталж байв. Тиймээс баруун хязгаар хийгээд Өвөр монголыг чөлөөлөн нэгтгэх асуудалд анхаарлаа хандуулжээ. Энэ үйлдэл нь Хаант Орос улсын бодлоготой ихээхэн зөрчилдсөн юм. Өвөр Монголчуудын тусгаар тогтнолоо шинээр сэргээсэн Монгол Улсад итгэж найдах гол тулгуур багана нь байв» (gogo.mn 2024) хэмээжээ.

1912 оны Орос-Монголын хэлэлцээрийн үеэр эсэргүүцэл илэрхийлж, Монгол Улсыг хүлээн зөвшөөрөхгүй бол хэлэлцээрийг таслана хэмээн мэдэгдэж, үүний улмаас хэлэлцээрт Монголын талыг толгойлохоо больж, Сайн ноён хан Намнансүрэн тэргүүлсэн ажээ. Тэр Монголын тусгаар тогтнолын баталгаа

зөвхөн Оростой холбоо тогтоосноор хангагдахгүй. Харин бусад хүчирхэг улсуудаар улсаа хүлээн зөвшөөрүүлэх нь чухал хэмээн үзэж байв. 1913 онд дээрх үзэл санаагаа гүйцэлдүүлэхийн тулд ван Гончигсүрэнгийн хамт Японтой харилцаа тогтоохоор Хайлаарт очиж, Оросын явуулгаар мухардалд ороод буцаж ирж байв.

Сайн ноён хан Намнансүрэнг 1912 оны 7 дугаар сард Засгийн газрын анхны Ерөнхий сайдаар томилсон юм. 1912 онд Монгол Оросын хооронд найрамдлын гэрээг байгуулж, 1913 оны 10 дугаар сард Хаант Орос улсад анхны төрийн дээд хэмжээнд айлчилж Оросод 3 сар орчим байхдаа Сайд нарын зөвлөлийн дарга, Гадаад яамны сайд нартай удаа дараалан уулзаж, П.Николай хаанд хоёр ч удаа бараалхжээ. Ингэхдээ Оросын талд хандан Монгол Улс байгуулагдсаныг хятадаар хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт тавьж, 1913 оны Орос, Хятадын тунхагийн үзэл санааг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ албан ёсоор илэрхийлсэн юм. Мөн Петербургт сууж байхдаа Англи, Америк, Япон, Хятад, Швейцарь, Франц, Герман, Итали, Турк, Голланд, Дани, Австри зэрэг 10 гаруй улс орны элчин сайдын яаманд тусгаар тогтнолын тухай нот бичиг хүргүүлэхэд Хятадаас бусад нь хүлээн авчээ. Тэрбээр Хаант Оросоос зэвсгийн туслалцаа гуйсан боловч тэд хариуд нь Барга, Өвөр Монголын нутгаас Монгол Улсыг цэргээ татахыг шаардсан байна. Ийнхүү аргагүй эрхэнд Оросын шахалтаар цэргээ татсанаар хятадууд Өвөр Монголд цэргийн хүчээ оруулсан чигээр үлдэж, Монголын өвөр нутаг хятадын мэдлийнх болсон ажээ.

Т.Намнансүрэн Монгол туургатныг нэгтгэсэн улс байгуулах хэргийг Хаант Оросоор зөвшөөрүүлэх гэж хичээнгүйлэн зүтгэсэн боловч талаар болсонд их л дурамжхан нутагтаа эргэж иржээ. Гэвч Ховдын хязгаарыг өөртөө нэгтгэх явдлыг Хаант Оросоор зөвшөөрүүлсэн нь том амжилт байсан юм. Намнансүрэн гурван улсын хэлэлцээрт Япон улсыг оролцуулах боломжийг судалж Японы эзэн хаанд захидал илгээж, Далам Цэрэнчимэдийг 1914 онд Япон руу илгээх оролдлого хийсэн юм. Энэхүү хэлэлцээрт дөрөвдөгч, тавдагч орнуудыг оролцуулбал Монгол улсад ашигтайгаар эргэх боломжтой хэмээн үзэж байсан боловч Японы тал Оросын бодлогын улмаас тэрхүү бичгийг хүлээж авалгүй буцаасан түүхтэй.

Тэрээр Ерөнхий сайдын албыг хашиж байхдаа 1913 онд “Шинэ толь”, 1915 онд “Нийслэл хүрээний сонин бичиг”-ийг гаргасан нь маш дэвшилтэт үйл ажиллагаа байсан юм. 1915-1918 онд төрийн сүлд, далбаа, үндсэн хуулийн агуулга бүхий 65 дэвтэр “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”, Монгол улсын цэргийг шинэчлэн байгуулах дүрмийг боловсруулан гаргаж, өөрийн байгуулсан Дээд ба Доод хурлаар хэлэлцүүлэн батлуулжээ. Эдгээр хурлууд нь 1914 оны 2 дугаар сард байгуулагдсан бөгөөд Дээд хурал нь 50-60 хүний бүрэлдэхүүнтэй, харин Доод хурал нь 70-80 хүнтэй байжээ.

1911 оны намар Халхын Хүрээний Газрын Бүгд Хэргийг Түр Ерөнхийлөн Захиран Шийтгэх Газар буюу Түр засгийн газар байгуулж даргаар нь Түшээ гүн Г.Чагдаржавыг томилсон байна. Уг Засгийн газраас тусгаар улсаа зарлахаар бэлдэж байгааг улс

орны бүх нэгжид мэдээлж, Манж Чин улсын төлөөлөгчдийг албадан гаргаж, мөн Улиастайн жанжинг орхиж явуулахыг сануулсан, Хиагтын гаалийг мэдэлдээ авсан, зэр зэвсэг цэрэг цуух цуглуулсан, улсаа тогтнуулах ухуулах тараасан зэрэг бүхий л бичиг баримт тушаал шийдвэр Түр засгийн Ерөнхий сайд Чагдаржавын нэрээр үйлдэгдсэн буй. Өлзийт өдөр Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын хаан ширээнд залахад Чагдаржав ван Богдод төрийн тамгыг гардуулсан байна. Мөн тэрээр “Таван замын байлдаан”-ы ерөнхийлөн захирагч сайдаар ажиллаж, нэгэн жигүүрийг нь удирдсан (Eagle.mn 2024) ажээ. Түүний улс төрийн уян хатан ухаалаг бодлого нь улс орныг тусгаар тогтнох их үйлсэд ч нөлөөлсөн гэдгийг түүх судлаачид хэлдэг. Г.Чагдаржавыг Монголын тусгаар тогтнолын том зүтгэлтэн гэж үздэг (News.mn 2023). Түүхч, профессор Ж.Урангуа «...Түшээ гүн Г.Чагдаржав Монгол Улсын Санхүүгийн төв байгууллагын тулгын чулууг тавьж, төсөв санхүүг барих, улсын сангийн орлогыг нэмэгдүүлэх, татварын бүрдүүлэлтийг цэгцлэх, байгалийн баялгаас олох орлогыг нэмэгдүүлэх, худалдааны бодлогод шинэчлэл хийж улс орноо тухайн цагийн түвшний улс шиг улс болгохын төлөө амсхийх чөлөөгүй зүтгэсэн байдаг. Оросоос хатуухан болзолтойгоор авсан 6000 гаруй рублийн зээл мөнгө санхүүгийн хэрэгцээг бүрэн бус боловч хангаж байсан. Тухайн үед санхүүгийн туршлагатай мэргэжилтэн хүн ховор, хөрш орнууд Монголд туслахаасаа илүүтэй Монголыг эрхшээлдээ оруулахыг хичээж байсан зэрэг хүнд цаг үеийг Г.Чагдаржав туулсан ч түүний эх орноо гэсэн сэдэл тэмүүлэл

нийгмийн сэтгэхүйд маш хүчтэй байсан нь аливаа бэрхшээлийг давахын төлөөх үйл ажиллагааг идэвхжүүлж байсан. Монголын эдийн засаг сул ядуу байсан ч нийгэмд хөнөөлт хар тамхи, архи, дамын наймаа зэргээр ашиг олохыг Монголын Засгийн газар эрс эсэргүүцэж байсан» (News.mn 2023) хэмээжээ. Тэрээр Орос, Монгол, Хятад гурван улсын гэрээнд гол үүрэгтэйгээр оролцсон төдийгүй тусгаар Монгол Улс байгуулах үйл хэрэгт эх орончийн байр сууриас хүчин хүчин зүтгэж байсан нөлөө бүхий ноёдын нэг байлаа. Тиймээс Олноо өргөгдсөн Богд Хаант Монгол Улсыг тунхаглан, төрийн яамдыг байгуулахад Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэх яамны анхны тэргүүн сайдаар томилогджээ. Түүхч О.Батсайхан «... *Хиагтын гурван улсын гэрээний үеэр Орос, Хятадын төлөөлөгчид, ялангуяа хятадын эрх баригч Монголыг “Улс” хэмээн томъёолохыг эрс эсэргүүцэж, “Хэрэв улс хэмээн бичвээс Хятадаас салсан болох ба Орос улс залгихад хүрнэ»* гэхчилэнгээр Монголын төлөөлөгчдийг айлган сүрдүүлэх оролдлого нэг бус удаа гарч байсан ч Г.Чагдаржав нар алсын хараа, ноён нуруу, уужуу тайван сэтгэл, тэвчээр зориг зааж давч гарч чадсан нь түүхийн баримтад үлдсэн. Энэхүү гурван улсын гэрээний үеэр Монголын хил хязгаарын асуудлыг хэлэлцэхэд Г.Чагдаржав нар үнэхээр мэдлэг чадвар гаргаснаар өдгөө Монгол нутгийн Дарьганга, Цагаан түнх зэрэг газрыг оруулахгүй байх гэсэн Хятадын төлөөлөгчдийн санаархлыг тас цохиж чаджээ. Гурван улсын гэрээнд оролцогчдын зүтгэлийг Богд хаантнаас сайшаан тэмдэглэж, Чагдаржавт зарлигаар үе улиран засаг хошой чин вангийн хэргэм шагнан

хүртээж байсан” (News.mn 2023) гэжээ.

1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал хийгээд Богд хаант Монгол Улсын Засгийн газарт хүчээ өгсөн төрийн зүтгэлтний нэг бол Чин зүтгэлт гүн Баянтөмөрийн Хайсан юм. Тэрээр 1907 онд Өвөр Монголоос Их хүрээг зорин ирж, монгол туургатнаа тусгаар улс болгохын төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэсэн байна. Монгол туургатан эх орончид эрх чөлөөний үзэл санаагаа Богд Жавзандамба хутагтаар дэмжүүлж, улмаар Хаант Орос улсаас дэмжлэг хүсэх бүрэлдэхүүнд Хайсан гүн оролцож, энэхүү үйл хэрэгт эхнээс нь хүчин зүтгэсэн юм.

1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал ялсны дараа Богд хаант Монгол Улсын Дотоод яамны дэс түшмэлээр ажиллаж байсны дээр Ховдыг чөлөөлөхөд идэвхтэй оролцсон учир “Түшээ гүний” зэргээр шагнагджээ. Монгол улсын тусгаар тогтнолыг олон улсаар хүлээн зөвшөөрүүлэх үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулж байсан нь түүний гадаадад дотоодод явуулж байсан үйл ажиллагаагаар гэрчлэгддэг. Дэлхийн улс төрийн амьдрал, эдийн засгийн талаарх мэдээлэл өргөнтэйн учир Б.Хайсан гадаад харилцаандаа түлхүү анхаарч улс орныхоо эдийн засгийг чадавхжуулах арга замыг хайж, гадаад түншлэлд ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байжээ. Хятад, Орос хоёрын эдийн засгийн мөлжлөгийг сааруулах, тэнцвэржүүлэхийн тулд гадаад ертөнцөөс гуравдагч орны хөрөнгийг татах харилцан эрх тэгш ажиллах сувгийг татахыг эрмэлзэж байсан нь түүний сэтгэлгээний царыг харуулж байв.

III. Дүгнэлт

Дээрх сайдуудын улс төрийн үйл ажиллагаанаас Богд хаант Монгол Улсын гадаад дотоод бодлого болон Богд Жавзандамба хутагтыг улс төрийн хошуучлагчийн хувьд ямархан цар хүрээтэй төрийн зүтгэлтэн болохыг илтгэн харуулна. 1919 онд хятадууд цэргийг хүчээр монголын автономыг цуцлахад Богд хаан гарын үсэг зураагүй юм. Харин ч төрийн тусгаар тогтнолоо сэргээхийг эрмэлзэн АНУ, ЗОУ, Япон болон Колчакийн засгийн газраас тусламж дэмжлэг эрэлхийлж байсан хүмүүсийг дэмжиж байв. Мөн ардын нам, ардын хувьсгалын үйл хэргийг эхнээс нь дэмжиж ЗОУ-аас тусламж гүйх бичигт тамга дарж өгчээ. Хятадын эрх баригчид Хүрээ, Ховд, Улиастайн монгол захиргаанд чандлан тушааж, ЗОУ-д явсан 7 хүнийг барьж өгвөөс хүн тус бүрийн тоогоор түмэн төгрөг шагнан өгөх тухай зарлал бичгийг Хүрээний гудамжнаа энд тэндгүй наасан байв. Ардын хувьсгалын үйл хэргийг санаачлан хэрэгжүүлэгч Д.Бодоо, Д.Догсом нар Хүрээнд ирсэн даруйдаа Дэндэв, Дугаржав, Галсан нартай нууцаар уулзан Орост явсан хэргийн төлвийг тодорхойлон айлтгал бичиг бичиж, Дэндэвээр уламжлуулан Богдод толилуулсны хариуд Богдоос хятадын гарт баригдан, намын үйл хэргийг бүрмөсөн таслахаас сэргэмжлэхийг зөвлөжээ.

1921 оны хоёрдугаар сард Хүрээг эзлэн авсан Барон Унгерн монголын автономыг сэргээн мандуулснаа тунхаглаж Богд гэгээнийг Монголын хаан ширээнд залсан бол таван сарын дараа ардын намынхан Нийслэл Хүрээнд орж ирээд мөн л VIII Богдыг хаанаар өргөмжилжээ. 1921 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр

Ардын засгийн газраас Богд хаантай “тангарагийн гэрээ” байгуулж хааны улс төрийн эрх мэдлийг хасаж хэмжээт эрхтэй хаан болгожээ.

Ийнхүү 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал болон 1921 оны Ардын хувьсгалын үйл хэрэгт үнэлж баршгүй түүхэн үүрэг гүйцэтгэсэн төрийн зүтгэлтэн бол VIII Богд Жавзандамба хутагт юм. Доктор Г.Дашням, «...Түүхийн шинэ нөхцөлд Монголын тусгаар тогтнолын хэрэг явдал, түүнд өөрийн гүйцэтгэвэл зохих үүргээ зөвөөр ухамсарлаж, Монголын ноёд, лам нарын хүчийг нэгтгэн, зохион байгуулж удирдсан нь VIII Богд Жавзандамба хутагтын Монголын түүхэнд гүйцэтгэсэн нэгэн гавьяа болно» (Сүхбаатар О., Энхжин С. 1999) гэжээ. Улс төр судлаач Л.Пүрэвдорж «... улс төрийн хошуучлагч нь зохион байгуулах удирдах ёсны, үзэл санааны дагуулан тэргүүлэх оргил субъект болдог онцлогтой» (Academy.edu 2020) хэмээн хошуучлагчийн дүр төрх, байр суурь, үүрэг, үйл ажиллагааны онцлог шинжийг тодорхойлсон байна. Харин Монгол Улсын түүхийн I ботид “Өрнөдийн улс төр судлалд өргөн тархсан М.Веберийн ангиллаар бол Богд гэгээн 1911 оны үндэсний хувьсгалд “үзэл сурталч, хошуучлагч” байр суурьтай оролцсон» (Academy.edu 2020) хэмээжээ.

Бид түүхийн бодит үнэнийг тодруулж, ирээдүй хойч үеэ түүгээр хүмүүжүүлж, төлөвшүүлэх явдал нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд шууд холбогдох асуудал юм. 1990 он хүртэл бидний түүх нэг үзэл суртал, ангич, намч хандлагын үүднээс бичигдэж, нийгмийн оюун санаанд гүн бат шингэсэн байв. Хэт нэг талыг барьж туйлширсан түүхэн болон

уран сайхны кино, жүжиг, дуурь, баримтат кино, дуу, ном зохиол зэрэг соёл урлагийн бүтээлүүд “борооны дараах мөөг” шиг олширсон. Эдгээр бүтээлүүд хувьсгалын үйл хэргийг магтан дуулж, монголын уламжлалт бурхны шашин, соёл, зан заншил ахуйг “бүдүүлэг”, “хоцрогдсон” гэх зэргээр үгүйсгэж байв. Энэ нь түүхэн бодит үнэнийг алсруулах, тухайн үеийн төрийн зүтгэлтэн буюу улс төрийн хошуучлагчийн үйл хэргийг харлуулж, бараантуулахад чиглэгдэж байсан юм.

Богд Жавзандамба хутагтын улс төрийн үйл ажиллагаа нь монгол үндэстнийг туурга тусгаар улс болгоход хүчин чармайлт гаргаж, цаг үеэ гярхай мэдэрсэн улс төрийн хошуучлагчийн холч ухаан юм. Түүний энэхүү гавьяа зүтгэл нь эдүгээгийн Монгол Улсын оршин тогтнож буй гол үндэс билээ.

Ашигласан материал

- ШУА, Түүхийн хүрээлэн. 1995. *XX зууны Монгол*. Улаанбаатар: Түүхийн хүрээлэн, ШУА.
- Лүндэндорж Н. 2002. *Монголын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний зарим асуудал*. Улаанбаатар: МУИС, Хууль зүйн сургууль.
- Дулам С. 2015. “Монголчуудын хүмүүнлэг ардчилсан үзэл сэтгэлгээ”. *“Монголын нийгэм улс төрийн сэтгэлгээний түүхийн асуудал” /Философийн ухааны доктор, профессор Дуламын Дашижамцын мэндэлсний 85 жилийн ойд зориулсан эмхэтгэл*. Улаанбаатар: Философийн хүрээлэн, ШУА, “Соёмбо принтинг” ХХК. 232.
- Дэндэв Л. 1934. *Монголын товч түүх*. Улаанбаатар.

Улс төрийн хошуучлагчийн бодлого, үйл ажиллагаа нь төрийн тогтвортой байдал, хөгжил дэвшилтэй нягт уялдаа холбоотой оршдог байна. Төрт ёсыг уламжлан авч хэрэгжүүлдэг гол субъект нь улс төрийн хошуучлагч юм. Өнөөгийн монголын нийгэм, улс төрийн зүтгэлтүүд өнгөрүүлсэн түүхээсээ сургамж авч, уламжлал, шинэчлэлийг хослуульж, дэлхийн олон улс, гүрэнтэй, эвсэг найрсаг, харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлж, хөгжил дэвшилд хүрэх нь чухал юм. Нөгөөтээгүүр иргэдийн нийгмийн оюун санаа, ухамсарт эерэг нөлөө үзүүлэхүйц орчин ахуйг бүрдүүлэхэд хүчин чармайлт гаргаж, бодлого боловсруулж, хэрэгжүүлж чадах аваас монгол төр бэхжин төгөлдөржих боломж бүрдэнэ. Үүнд улс төрийн хошуучлагчдын байр суурь, үзэл бодол, үйл хэрэг ямагт эн тэргүүнд тавигдсаар байх болно.

- МУИС. 1999. *Монгол Улсын түүх*. ред. Болдбаатар Ж. Улаанбаатар: МУИС, НШУС.
- 1938-1939. *Международные отношения в эпоху империализма: (1870-1910)*. Москва.
- Түүхийн хүрээлэн. 1972. *В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр.
- МУТТА. n.d. ФА-1. ХН-1.6-1.
2024. *Gogo.mn*. <https://gogo.mn/t/8xneg>.
2024. *Eagle.mn*. <https://eagle.mn/t/66272>.
2023. *News.mn*. <https://news.mn/t/2230707/>.
- Сүхбаатар О., Энхжин С. 1999. *XX зууны Монголын түүхийн зарим асуудал*. Улаанбаатар.